



Европын Холбоо  
санхүүжүүлэв



Food and Agriculture  
Organization of the  
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын  
Хөдөлмөрийн  
Байгууллага



# БҮТЭН БУС ЦАГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА 2024

## ХУРААНГУЙ ҮР ДҮН

### СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар, Хөвсгөл, Орхон, Дархан-уул аймаг  
108 ААНБ  
1,002 бүтэн бус цагаар ажиллагчид



### ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

#### БҮТЭН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ГЭЖ ХЭН БЭ?

Ажлын бүх цаг нь Хөдөлмөрийн хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 40 цагаас бага, өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн хүн.

#### БҮТЭН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ХЭН СУДАЛДАГ ВЭ?



##### Үндэсний Статистикийн Хороо

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын аргазүйгээр хийдэг Ажиллах хүчний судалгаа

- Улсын хэмжээнд 1,128,447 ажиллагсад байгаагийн 0.4% буюу 4,016 нь бүтэн бус хөдөлмөр эрхлэгч (2022 оны улирал I)



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУРГАЛТ, ҮНЭЛГЭЭ, СУДАЛГААНЫ  
ИНСТИТУТ

##### Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институци

Хоёр жил тутмын Цалин хөслний бүтцийн судалгаа

- Судалгаанд хамрагдсан нийт 2,474 ААНБ-ын 2,087 ажиллагсдын 3.2% буюу 749 нь бүтэн бус хөдөлмөр эрхлэгч (2021 он)

#### ЦАЛИН ХӨЛСИЙГ ХЭРХЭН ТОГТООДОГ ВЭ?

Төр, ажил олгогч болон ажилтаны эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл бүхий гурван талт Үндэсний хороо Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоодог.  
2024 оны 1 сарын 1-ээс хөдөлмөрийн хөлсний

доод хэмжээ 660,000 төгрөг болсон. Энэ хэмжээг салбарын хамтын хэлэлцээрээр тухайн салбарын хүрээнд нэмэгдүүлж тогтоох боломжтой. Тухайлбал дараах 13 салбар хамтын хэлэлцээрийн хүрээнд Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлсэн:

- Авто тээвэр • Харилцаа холбоо • Мэдээлэл технологи • Газрын тос • Иргэний нисэх • Эрүүл мэнд • Авто зам • Соёл урлаг, спортын салбарын төрийн үйлчилгээ • Геологи уул, уурхай хүнд үйлдвэр • Эрчим хүч; Барилга • Орон сууц, нийтийн аж ахуй • Хоол үйлдвэрлэл үйлчилгээ • Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчин.

# АЖИЛ ОЛГОГЧДООС АВСАН СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

## СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГЫН ЧИГЛЭЛ, ЦАГИЙН АЖИЛТНЫ ХЭРЭГЦЭЭ

ХАА, ойн аж ахуй, загас, ан агнуур	5%	9%
Барилга	8%	8%
Бөөний болон жижиглэн худалдаа	31%	31%
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	6%	8%
Байр, сууц болон хоол хүнсний үйлчилгээ	18%	19%
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	8%	9%
Эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	5%	2%
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1%	1%
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	18%	16%


■ Хувиар ■ Цагийн ажилтны хэрэгцээ

## БҮТЭН БУС ЦАГААР АЖИЛТАН АВАХ ШААРДЛАГА

Ачаалал ихсэх үед	37.4%
Сул орон тоог нөхөх	8.4%
Үндсэн ажилтан тогтворгүй	1.9%
Хүн хүч дутагдалтай, засвар, бусад ажил гарах үед	9.3%
Барилга, ГТ гэх мэт улирлын ажлуудад	3.7%
Ээлжийн амралттай, чөлөөтэй ажилтны орон тоонд	3.7%
Зарим шаардлагатай үед нарийн мэргэжлийн ажилтан	12.1%
Шинэ бүтээгдэхүүн танилцуулах, амталгаа хийлгэх	5.6%
Оюутнуудыг дадлагажуулах	10.3%
Бараа бүтээгдэхүүн түгээх, борлуулах	3.7%
Тогтмол ажилтантай тул авдаггүй	3.7%

### ДҮГНЭЛТ 1:

Бүтэн бус цагийн ажилтны цалинг дийлэнх ажил олгогч төсөвлөхдөө хөдөлмөрийн зах зээл дэхь доод ханшыг харгалзан тогтоож байна. Бүтэн бус цагийн ажилтны цалингийн доод болон дундаж хэмжээг салбар тус бүрээр олон нийтэд мэдээлэх хэрэгцээ байна.



### ДҮГНЭЛТ 2:

Судалгаанд оролцсон 5 байгууллага тутмын 2 нь Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой Хөдөлмөрийн тухай хуулийн заалтыг биелүүлэхгүй байна.

Хөдөлмөрийн гэрээ	38	35.1%
Иргэний хуулийн дагуу ажил гүйцэтгэх гэрээ	43	39.8%
Аман тохиролцоогоор	14	13%
Байдаггүй	11	10.1%
Бусад	2	1.9%
Нийт судалгаанд хамрагдагчдын тоо	108	

Тайлбар\* Судалгаанд оролцсон байгууллагуудын байгуулж буй гэрээний хэлбэр

### ДҮГНЭЛТ 3:

ААНБ ажилтнаа ажлын зар, цахим сайтаас хайж, олж авч байгаа ба хөдөлмөр эрхлэлтийн албадаас (төрийн) үйлчилгээ авахгүй байна.

Ажилтан авах тухай зарлалыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан гаргадаг	59
Нийслэл, дүүргийн хөдөлмөрийн байгууллага, сум, хорооны ажилтан	2
Хөдөлмөр зуучлал(бирж)-ын газарт ханддаг	29
Өөрийн цахим хуудсаар дамжуулж	19
Ажлын байрны зарын сайтуудаас	76
Бусад (танилаараа)	11

### ДҮГНЭЛТ 4:

Бүтэн бус цагаар ажиллагсдыг үндсэн ажилтнаар сургаж авах нь түгээмэл байна.



### ДҮГНЭЛТ 5:


Бүтэн бус цагаар ажиллагсдыг сургах, дадлагажуулах хэрэгцээ өндөр байна.

Цагийн ажилтан олддоггүй	75
Хариуцлага муу	29
Ажлын гүйцэтгэл тааруу	32
Цаг баримталдаггүй	49
ХАБЭА-н дүрэм журам мөрдөхдөө тааруу	22
Цалин хөлсөө голдог	25
Янз бүрийн зөрчил гаргадаг	8
Заавал сургалт хийх зардал гардаг	13
Дадлагажуулах шаардлага гардаг	53
Бие даан ажиллах чадвар сул	22
Ажилдаа өөриймсөг сэтгэл дутмаг	25
Ур чадвар тааруу	12
Боловсролын түвшин тааруу	1
Хуулийн дагуу зохих татвар, шимтгэл суутгахад дургүй	15
Тухай бүр хөдөлмөрийн гэрээ бичгээр хийхэд төвөгтэй	9
Бусад	3

# АЖИЛТНУУДААС АВСАН СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

## ДҮГНЭЛТ 6:

19-44 насны иргэд бүтэн бус цагийн хөдөлмөр эрхлэх хандлагатай ба дийлэнх нь эмэгтэйчүүд байна.




Эмэгтэй



Эрэгтэй




## СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН БОЛОВСРОЛ БОЛОН БҮТЭН БУС ЦАГИЙН АЖИЛ ЭРХЛЭХ БОЛСОН ШАЛТГААНЫ ХАМААРАЛ (ХУВИАР)



## ДҮГНЭЛТ 7:


Судалгаанд хамрагдсан иргэдийн цагийн ажил хийх болсон шалтгааныг боловсролын түвшингээр харуулвал бүрэн дунд болон дипломын дээд боловсролтой иргэд бүтэн бус цагийн ажлыг хийх хандлагатай байгаа ба дийлэнх нь суралцахынхаа зэрэгцээ ажиллах шаардлагатай гэж илэрхийлсэн байна



## ДҮГНЭЛТ 8:

Судалгаанд хамрагдсан иргэдийн 50-с дээш хувь нь цагийн 1,000-5,000 төгрөгийн цалин авч байгаа ба ихэнхдээ ажилласан цагаар бодуулж авсан байна.

### Таны ажлын хөлс цагт дунджаар хэдэн төгрөг вэ?




### Таны цагийн ажлын цалин хөлсийг ямар хэлбэрээр олгодог вэ?



### ДҮГНЭЛТ 9:

Бүтэн бус цагийн хөдөлмөр эрхэлж буй иргэд цалин хөлсөө авахад аливаа саад бэрхшээл гардаггүй ба цөөн тохиолдолд дутуу, удаасан, бууруулсан огт авч чадаагүй тохиолдол илэрсэн байна.


### Та тохирсон ажлын хөлсөө авахад саад учирч байсан уу?



### ДҮГНЭЛТ 10:

Хөдөлмөрийн харилцааны талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон бусад чиглэлээр ажил олгогчдын чадавх бэхжүүлэх хэрэгцээ байна.

### Та цагийн ажил хийхдээ ямар нэгэн гэрээ хэлцэл хийж байсан уу?



### ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НӨХЦӨЛ

#### Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл




### ДҮГНЭЛТ 11:

Бүтэн бус цагийн ажлын мэдээллийг зар, найз нөхдөөс ихэнхдээ авдаг, харин төрийн хөдөлмөрийн албадад хандах нь хязгаарлагдмал байна.


### ДҮГНЭЛТ 12:

Залуучуудын хувьд бүтэн бус цагийн ажлын уян хатан нөхцөл, хичээл хийх боломжийг бүрдүүлдэг хэмээн энэ хэлбэрийг илүү сонирхож байна.

### Та цагийн ажлын тухай мэдээллийг хаанаас олдог вэ?



### Цагаар ажиллахын давуу талыг дурьдаж бичнэ үү?



### ХОЛБОО БАРИХ

Европын Холбооны санхүүжилттэйгээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй "Монгол улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төсөл